



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

“Налайхын Барилгын материалын
үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит
төсөвт үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулж, дүрмийг
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалт, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.“Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг “Налайхын үйлдвэрлэл, технологийн парк” хаалттай хувьцаат компани болгон өөрчлөн байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

2.Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг хаалттай хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсантай холбогдуулан хууль, тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Н.Баярчимэг)-нд даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 148 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1116100905

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 38
дугаар тогтоолын хавсралт

“НАЛАЙХ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрэм нь “Налайх үйлдвэрлэл, технологийн парк” хувьцаат компани (цаашид “компани” гэх)-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон үндсэн баримт бичиг мөн.

1.2. Компани нь орон нутгийн өмчийн оролцоотой хаалттай хувьцаат компани байна.

1.3. Компанийн оноосон нэр нь “Налайхын үйлдвэрлэл, технологийн парк” хувьцаат компани бөгөөд орон нутгийн өмчит хувьцаат компани байна. товчилсон нэр нь “НҮТП” ХК, (англиар “Nalaikh Industrial and Technology Park” closed joint-stock company, товчилсон нэр нь “NITP” closed JS)

1.4. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна.

1.5. Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний ерөнхий захиргаа буюу гүйцэтгэх удирдлага байршиж байгаа газрын хаягаар тодорхойлно.

1.6. Компани нь өөрийн бэлгэдэл (лого, туг)-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга тэмдэг хэрэглэнэ.

1.7. Бэлгэдэл, тэмдгийн загварыг Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.

ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

2.1. Компани нь хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхэлдэг байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжигддаг, ашгийн төлөө хуулийн этгээд байна.

2.2. Компани нь Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай” хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан дүрэм, бодлого, шийдвэр болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

2.3. Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

2.4. Компанийн хөрөнгө нь эзэмшиж байгаа биет болон биет бус хөрөнгөөс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

2.5. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

2.6. Компани өөрийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээ, мэдээллийг хууль тогтоомжийн дагуу тухай бүр өөрийн цахим хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлнэ.

2.7. Компани нь байгууллагын санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, төсөв болон үйл ажиллагааны орлогыг дүрэмд заасан үйл ажиллагаа, батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор зарцуулна.

2.8. Хувьцаа эзэмшигч нь хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тодорхойлсон бүрэн эрхэд нь хамааруулснаас бусад асуудлаар компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд шууд оролцохгүй бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн эзэмшлийн хувьцаанд нийлүүлэн санал гаргана.

2.9. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй ба гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ. Компани нь бусад хувьцаа эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг хүлээхгүй.

ГУРАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ЗАРЧИМ

3.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь нийгэм эдийн засаг, байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөлөлгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ, дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар төлөвлөгдсөн газрыг паркийн бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;

3.2. Барилгын материалын үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн паркийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг нарийвчилж тооцсон хөгжлийн үе шатны төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах;


3.3. Хариуцсан ажил үүргийн чиглэлээр паркийн бүсийг хөгжүүлэх, төлөвлөх, орчноо тохижуулах үйл ажиллагаанд хувийн хэвшил, холбоод, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог ханган, тэдний санал санаачилгыг хөгжлийн төсөл, хөтөлбөрт тусгах, хамтран ажиллаж нэгдсэн удирдлагаар хангах;

3.4. Компани нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авч барилгын материалын үйлдвэрлэл, технологийн чиглэлээр үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж ашиг олж Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх

3.5. Компани нь Нийслэл Улаанбаатар хотын бүтээн байгуулалт, барилга, орон сууцны салбарт үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг бий болгох хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг өсгөх, барилгын материалын үйлдвэрлэл, технологийн чиглэлээр инновацад тулгуурлах хөгжүүлэх үйл ажиллагаа явуулах, паркт байрших үйлдвэрүүдийг дэд бүтцээр хангах чиг үүрэг бүхий компани мөн.

3.6. Компани нь дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ.

- 3.6.1 Барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- 3.6.2 Барилгын материал үйлдвэрлэлд хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх;
- 3.6.3 Хөрөнгө оруулалтыг дэмжих;
- 3.6.4 Дэд бүтцийн хөрөнгө оруулалт босгох;
- 3.6.5 Парк хөгжүүлэх хөрөнгө оруулалтын санг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд болон зээл төлөх, парк хөгжүүлэх зорилгоор байгуулах;
- 3.6.6 Хөнгөн, хүнд үйлдвэрийн салбарын мэргэшсэн ажилтан бэлтгэх зорилгоор сургалтын төв, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг байгуулах;
- 3.6.7 Паркийн харьяа аж ахуйн нэгж байгуулах, орлого олох боломжийг Нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх ба олсон орлогын тодорхой хэсгийг паркийн материаллаг баазыг бэхжүүлэх, ажилчдын нийгмийн хангамжийг сайжруулах ажилд зарцуулах;
- 3.6.8 Паркийн бүсэд үйлдвэрлэгчдэд цахилгаан, дулаан, ус, бохир усан хангамжийн болон эрчим хүчний хэрэглээний зардлыг бууруулж дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 3.6.9 Паркийн эрдэм шинжилгээний байгууллага болон үйлдвэрүүдэд тулгуурлан мэргэшсэн ажилчин бэлтгэх, сургах сургалтын төвийг байгуулах;
- 3.6.10 Паркийн салбар Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн үйл ажиллагаа эрхлэх,



- 3.6.11 Тээвэр, ложистикийн үйл ажиллагаа эрхлэх
 - 3.6.12 Барилгын материалын стандартын лабораторийн төв байгуулах, үйл ажиллагаа эрхлэх
 - 3.6.13 Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулах, үйл ажиллагаа эрхлэх
 - 3.6.14 Бүх төрлийн батарей, автомашины хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллах, хадгалалт хамгаалалт хариуцах үйл ажиллагаа эрхлэх.
 - 3.6.15 Гааль, татварын 1 цэгийн үйл ажиллагаа эрхлэх.
 - 3.6.16 Цэцэрлэгжүүлэг, ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхлэх
 - 3.6.17 Кластерийн систем хөгжүүлэх бизнес инкубатор төв байгуулах, ажиллуулах.
 - 3.6.18 Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа эрхлэх.
- 3.4. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн явуулна.
- 3.5. Компани нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:
- 3.5.1. бие даасан байх;
 - 3.5.2. хараат бус байх;
 - 3.5.3. олон нийтэд ил тод байх;
 - 3.5.4. ажилтнуудын эрх ашгийг хамгаалж үйл ажиллагаандаа хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;
 - 3.5.5. эрсдэлийн зохистой удирдлага, эрсдэлээс сэргийлэх арга, хэрэгсэлтэй байх.
- 3.6. Компани ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэн, хувьцаа эзэмшигчийн үр өгөөжийг тогтвортой хангаж, компанийн үнэ цэнийг өсгөхийг эрмэлзэнэ.
- 3.7. Компанийн хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлагын талаарх аливаа шийдвэр нь тухайн хөрөнгө оруулалтын эдийн засаг, санхүүгийн үр өгөөж, тооцоо, судалгаанд суурилсан байна.
- 3.8. Компанийг хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллага, Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэрээр компанийг өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгана.
- 3.9 Компани нь хязгааргүй хугацаагаар үйл ажиллагаа явуулна.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬЦАА, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

- 4.1. Компанийн зарласан энгийн хувьцаа нь нэг бүр нь 1000 (нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 73,910.241 (далан гурван сая есөн зуун арван мянга хоёр зуун дөчин нэг) ширхэг байна.
- 4.2. Компани нь нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 73,910.241 (далан гурван сая есөн зуун арван мянга хоёр зуун дөчин нэг) ширхэг хувьцааг эргэлтэд гаргах бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 73,910,240.000 (далан гурван тэрбум есөн зуун арван сая хоёр зуун дөчин мянга) төгрөг байна.
- 4.3. Компанийн энгийн хувьцаа нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас холбогдох шийдвэр гарах хүртэл гагцхүү Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэдэлд байх бөгөөд аливаа хэлбэрээр бусдад арилжаалагдахгүй.
- 4.4. Компани нь цаашид нэмж хувьцаа болон бусад үнэт цаас гаргах бол тэдгээрийн тоо, гаргах хугацаа, нөхцөлийг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 4.5. Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.
- 4.6. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ болон хөрөнгө оруулалтын хөрөнгөтэй харьцах харьцааны зохистой хувь, хэмжээ нь эрх бүхий байгууллагаас тогтоосны дагуу байна.

ТАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА

- 5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал
- 5.2. Төлөөлөн удирдах зөвлөл
- 5.3. Гүйцэтгэх удирдлага гэсэн шатлалтай байна.



ЗУРГАА.ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

6.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит, ээлжит бус байна.

6.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас компанитай холбогдон гарах шийдвэр нь "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк " ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал гэсэн нэрээр гарна.

6.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэнэ.

6.4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн (4) сарын дотор зарлан хуралдуулна.

6.5.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хууль, холбогдох дүрэм, журамд заасны дагуу зарлан хуралдуулж болно.

6.6. Хувьцаа эзэмшигчийн хурал нь дараах асуудлыг шийдвэрлэнэ .

6.6.1 компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах;

6.6.2 нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөн байгуулах;

6.6.3 компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

6.6.4 компанийн хэлбэрийг өөрчлөх;

6.6.5 компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

6.6.6 хувьцааг хуваах буюу нэгтгэх;

6.6.7 компанийн зарласан энгийн хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэх;

6.6.8 компанийн тухай хуульд заасны дагуу компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;

6.6.9 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

6.6.10 компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

6.6.11 компанийн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаарх тайланг хэлэлцэж шийдвэрлэх;

6.6.12 компанийн гүйцэтгэх удирдлагыг томилох, түдгэлзүүлэх, чөлөөлөх асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж өгөх;

6.6.13 компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

6.6.14 компанийн тухай хууль, энэхүү дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

6.7.Хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг зарласнаас хойш зайлшгүй хэлэлцэх асуудал гарсан бол хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар хэлэлцэж болно.

6.8.Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

6.9.Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийг тухайн асуудлын талаарх танилцуулга, мэдээлэл, тайлан зэрэг уг шийдвэрийг гаргах үндэслэл болсон мэдээллийн хамт компанийн архивд хадгална.

ДОЛОО. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.



7.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь ес (9) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 1/3 нь НИТХ-аас, 1/3 нь төрийн албан хаагч, 1/3 нь хараат бус гишүүн байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дараах шаардлага тавигдана:

7.2.1. барилгын материал үйлдвэрлэл, технологийн чиглэлээр гурваас (3) доошгүй жил ажилласан туршлагатай, энэ чиглэлээр мэргэшсэн;

7.2.2. банк бусад санхүүгийн компанид зөрчлийн улмаас тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үед нь удирдлагад нь ажиллаж байсан бөгөөд зөвшөөрөл хүчингүй болсноос хойш 3 жил өнгөрсөн байх;

7.2.3. барилгын материалын үйлдвэрлэлийн зах зээлд гаргасан зөрчлийн улмаас захиргааны хариуцлага хүлээснээс хойш нэг (1) жил өнгөрсөн байх;

7.2.4. хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэртэй өр төлбөргүй байх;

7.2.5. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;

7.2.6. Компанийг удирдахад тавигдах бусад шаардлага

7.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан этгээд байна:

7.3.1. тухайн компани болон түүний холбогдох этгээдэд ажил албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн гурван (3) жилийн хугацаанд эрхэлж байгаагүй;

7.3.2. бизнесийн харилцаатай компанийн ажилтан, албан тушаалтан биш байх.

7.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь түүний хурал байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурлыг хэдийд ч хийж болно.

7.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

7.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно.

7.7. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг байнгын, тогтмол, мэргэшсэн явуулах зорилгоор дараах хороодыг байгуулж ажиллуулах бөгөөд бусад тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.

7.7.1. барилгын материалын шинжилгээ, судалгаа;

7.7.2. технологи, инновац;

7.7.3. хөрөнгө оруулалт;

7.8. Хороод нь тус бүр гурван (3) гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс Төлөөлөн удирдах зөвлөл томилно.

7.9. Хороод нь өөрийн хариуцсан асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлд санал, дүгнэлт оруулж, хэлэлцүүлэх бөгөөд шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

7.10. Хороод нь өөрийн эрх, үүргийг тусгасан үйл ажиллагааны журмын төслийг Компанийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

7.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:


7.11.1. компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах;

7.11.2. компанийн хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлох;

7.11.3. компанийн стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөг батлах;

7.11.4. компанийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын дээд хязгаарыг тогтоох;

7.11.5. компанийн гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;



7.11.6. компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах;

7.11.7. компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, нээж ажиллуулах, татан буулгах, удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

7.11.8. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

7.11.9. компанийн зарласан хувьцааны төрөл, тоонд багтаан хувьцаа гаргах;

7.11.10. эд хөрөнгийн болон эд хөрөнгийг эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

7.11.11. компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

7.11.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг болон төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын дүрэм, журмыг батлах;

7.11.13. компанийн шинээр худалдаж авах болон акталж, данснаас хасах эд хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх;

7.11.14. компанид орсон орлогыг хуваарилах, хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээг тогтоох, батлах;

7.11.15. компанийн эрх бүхий албан тушаалтныг томилох;

7.11.16. компанийн мэдэлд үлдээсэн эрсдэлийн хуримтлалын хэмжээг тодорхойлох, зарцуулах журмыг батлах;

7.11.17. их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээ хэлцлийн үнэ болон хийх эсэх талаар шийдвэр гаргах;

7.11.18. компанийн үйл ажиллагаатай уялдуулан хөрөнгө оруулалтын, эрсдэлийн удирдлагын болон шаардлагатай бусад чиглэлээр орон тооны болон орон тооны бус зөвлөл, бусад нэгжийг байгуулах;

7.11.19. энэхүү дүрэм болон Компанийн тухай хуульд заасны дагуу зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээс бусад бүх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

7.11.20. хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасан бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.

7.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүдээс олонхын саналаар сонгоно.

7.14. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, түүнд хяналт тавих үүргийг хүлээнэ.

7.15. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаас үүрэг болгосны дагуу аль нэг гишүүн гүйцэтгэнэ.


7.16. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аль нэг хорооны даргын ажлыг хавсран гүйцэтгэхгүй.

7.17. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдуулна.

7.18. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нийт гишүүдийн дийлэнх олонх буюу гуравны хоёр (2/3) оролцсоноор хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонх буюу гуравны хоёр (2/3)-ын саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

7.19. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн зөвхөн өөрийн биеэр хуралд оролцож эрх хэмжээгээ хэрэгжүүлэх бөгөөд өөр этгээдээр төлөөлүүлж хуралд оролцохыг хориглоно. Хэрэв Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хуралд биеэр оролцоогүй ч тухайн хэлэлцэж буй асуудлын талаар бичгээр санал гаргасан бол түүнийг хуралд оролцсонд тооцно.

7.20. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудал хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг болон бусад холбогдох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.



7.21. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас томилно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.

7.22. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь цалин, урамшуулалтай байх бөгөөд цалин, урамшууллын хэмжээ нь нийслэлийн өмчит компани болон холбогдох эрх бүхий байгууллагаас тусгайлан тогтоосон жишиг хэмжээтэй нийцэхүйц байна.

7.23. Төлөөлөн удирдах зөвлөл нь жилд нэгээс (1) доошгүй удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

7.24. Төлөөлөн удирдах зөвлөлийн тухайн жилийн ээлжит болон ээлжит бус хурлын гуравны нэгээс дээш хувьд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй, санал өгөөгүй, энэ дүрмийн 6.12 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй гишүүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх асуудлыг хурлын тэмдэглэл бусад холбогдох бичиг баримтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

НАЙМ. КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

8.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэлцэл хийх, гэрээ байгуулах, паркад байрших үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага, компанитай гэрээ байгуулах, газар ашиглуулах, хөрөнгө оруулалтын болон бусад үйл ажиллагааны гэрээ байгуулах, компанийн эрх ашгийн төлөө түүнийг Монгол Улс болон хилийн чанадад төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

8.2. Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл хэдийд ч гаргаж болно.

8.3. Гүйцэтгэх захирал нь компанийн дэд захирал, ерөнхий нягтлан бодогч, салбар, төлөөлөгчийн газрын захирал, дарга нарыг томилох, түдгэлзүүлэх, чөлөөлөх тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд санал оруулж шийдвэрлүүлнэ. Шаардлагатай бол Төлөөлөн удирдах зөвлөл өөрийн санаачилгаар тэдгээрийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж болно.

8.4. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна:

8.4.1. менежментийн өндөр ур чадвартай, таваас (5) доошгүй жил удирдах ажил гүйцэтгэж байсан дадлага туршлагатай, дээд боловсролтой байх;

8.4.2 зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

8.4.3. ял шийтгэлгүй байх;

8.4.4. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;

8.4.5. эрх бүхий байгууллагаас барилгын материалын үйлдвэрлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах компанийг удирдахад тавигдах бусад шаардлага


8.5. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцоно.

8.6. Гүйцэтгэх захирал нь дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ:

8.6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд 1 удаа ажлын үр дүнгээ тайлагнан дүгнүүлэх;

8.6.2. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх үүрэгтэй бөгөөд түүний үнэн зөвийг хариуцах;

8.6.3. Паркад шаардлагатай хөрөнгө оруулалтыг улсын болон нийслэлийн төсөв, Засгийн газар болон төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;



8.6.4.Хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалт, компанийн хөдөлмөрийн дотоод журамд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

8.6.5.Компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулан шийдвэрлүүлэх, түүний хэрэгжилтийг зохион байгуулах;

8.6.6.Компанийн бодлого, түүний хэрэгжилттэй холбогдсон асуудлаар санхүүгийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж, холбогдох бусад байгууллагатай шууд харилцаж, байр сууриа илэрхийлэх;

8.6.7.Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний хүрээнд хамаарах асуудлаар компанийг төлөөлөх итгэмжлэл олгох;

8.6.8. Компанийн нууцад хамаарах мэдээлэл, материалын жагсаалт болон нууц хамгаалах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулан мөрдүүлэх

8.6.9.Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

8.6.10.Паркад байрших аж ахуйн нэгжүүдийг батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн сонгон шалгаруулах;

8.6.11.Үүрэг гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

8.6.12. Компанийн бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас чөлөөлөх;

8.6.13. Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулах;

8.6.14. Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

8.6.15. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах ажлыг хариуцан зохион байгуулах;

8.6.16. Компанийн бэлгэдэл, тэмдгийн загварыг батлах;

8.6.17. Хууль болон энэхүү дүрэм, гэрээнд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

8.7. Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, цалин, шагнал урамшуулал, хангамж, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээ болон бусад асуудлыг тусгаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна.


8.8. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийн үндсэн дээр зарим эрх, үүргээ итгэмжлэл гарган компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.9. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцоно.

8.10. Компанийн гүйцэтгэх удирдлага нь энэхүү дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, технологи, инновацын чиглэлээр мэргэжлийн, байнгын хоёроос (2) доошгүй зөвлөхийг авч ажиллуулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлж болно.

ЕС. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

9.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, асуудал эрхэлсэн газрын дарга, албаны дарга дотоод аудитор, ерөнхий нягтлан бодогч, салбарын эрхлэгч нарын этгээдийг компанийн эрх албан бүхий албан тушаалтанд тооцно.



9.2. Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуульд заасны дагуу өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх болон бусад мэдээллийг хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд өгч энэхүү дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

9.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй байна.

9.3.1. хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;

9.3.2. үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, Компанийн тухай хууль болон энэхүү дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;

9.3.3. үйл ажиллагаагаа хараат бус бие даасан байдлаар явуулж, хувьцаа эзэмшигч, харилцагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх;

9.3.4. шууд болон шууд бус байдлаар эсхүл гуравдагч талын нэрийн өмнөөс компанид нөлөөлж болох аливаа хэлцэл, материаллаг сонирхолтой асуудлын талаар төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх;

9.3.5. компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;

9.3.6. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөл, аудитор мэдэгдэх;

9.3.7. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх;

9.3.8. компанийн эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш арав (10) хоногийн дотор Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орох бүрд арав (10) хоногийн дотор компанид мэдэгдэнэ;

9.3.9. компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх;

9.4. Компанитай байгуулсан гэрээгээр илүү урт хугацаа тогтоогоогүй бол компанийн эрх бүхий албан тушаалтан албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш гурван (3) жилийн туршид энэ дүрмийн 8.3.9-д заасан үүргийг хүлээнэ.

9.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээ, компанийн хөдөлмөрийн дотоод журмаар тогтоох бөгөөд хариуцлагын арга хэмжээг тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРАВ. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

10.1. Компани нь барилгын материалын үйлдвэрлэл, хүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл үйл ажиллагааны журмын-д заасан Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх, хөрөнгө оруулалт босгох, захиран зарцуулах, хөрөнгийг хадгалах, зарцуулалтад тавих хяналтыг мөрдөж ажиллана.

10.2. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

10.2.1. хувьцаа эзэмшигчийн хяналт

10.2.2. дотоодын хяналт

10.2.3. аудитын хяналт

10.3. Хувьцаа эзэмшигчийн хяналтын чиг үүргийг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

10.4. Дотоодын хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон гурваас (3) доошгүй хянан шалгагчтай Дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ. Дотоод хяналтын албаны ажиллах журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална. Дотоодын алба нь байнгын ажиллагаатай байна.

10.5. Хянан шалгагч нь компанийн үйл ажиллагаа болон компанийн эх үүсвэрийг ашиглаж байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд түүний бүрэн эрхийн хугацаа гурван (3) жил байна.

10.6. Хянан шалгагч нь дараах эрхийг эдэлнэ:

10.6.1. төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн данс бүртгэл, тайлан тэнцэл, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа болон шаардлагатай бусад материалыг гаргуулж авах;

10.6.2. төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцан явцын тайлан холбогдох саналаа компанийн удирдлагад танилцуулах;

10.6.3. хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдуулан нарийн мэргэжлийн тусламж, дэмжлэгийг бусад байгууллага албан хаагчдаас авах;

10.6.4. шаардлагатай гэж үзвэл компаниас санхүүжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт, зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх;

10.7. Хянан шалгагч нь дараах үүргийг хүлээнэ:

10.7.1. хяналт шалгалт хийж байгаа байгууллагад сүүлийн (3) жилд өөрөө ажиллаж байсан болон гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн /хамт амьдардаггүй эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, хүргэн, бэр/ нь удирдах болон эрх бүхий албан тушаалд ажилладаг бол хяналт, шалгалт хийхээс татгалзах;

10.7.2. хяналт шалгалтын тайлан, мэдээг үнэн зөв, бодитой гаргах;

10.7.3. хяналт шалгалтыг бусад иргэн, байгууллага, албан тушаалтны ашиг сонирхол, нөлөөнд автахгүйгээр шударгаар, хараат бус хийж гүйцэтгэх;

10.8. Компани нь аудитын хяналтын зарчмыг үйл ажиллагаандаа баримтлах бөгөөд санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулан, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг хөндлөнгийн аудитын компаниар гүйцэтгүүлнэ.

10.9. Хөндлөнгийн аудиторын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАН

11.1. Компани нь олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.

11.2. Компанийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд түүнийг Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн Гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө.

11.3. Компанийн санхүүгийн жил нь тухайн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

11.4. Компани нь тусдаа санхүүгийн тайлан гаргах бөгөөд шаардлагатай гэж үзвэл хөрөнгө оруулалт хийсэн, хувьцаа эзэмшдэг бусад үйлдвэрүүдтэй хамтран нэгдсэн тайлан гаргаж болно.

11.5. Компани эзэмшиж буй аливаа хөрөнгийг санхүүгийн тайлан баланстаа тусгах бөгөөд хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг шаардлагатай тохиолдолд хөрөнгийн эрхийн бүртгэлийн байгууллагад, газар ашиглах, эзэмших эрхийг холбогдох байгууллагатай гэрээ байгуулан, барааны тэмдэг, нэр зэрэг оюуны өмчийг Монгол Улсын оюуны өмчийн холбогдох байгууллагад заавал бүртгүүлнэ.

АРВАН ХОЁР. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

12.1. Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана.

12.1.1. Баланс;

12.1.2. орлого, үр дүнгийн тайлан;

12.1.3. мөнгөн гүйлгээний тайлан;



- 12.1.4. өмчийн өөрчлөлтийн тайлан;
- 12.1.5. хуримтлагдсан ашгийн тайлан;
- 12.1.6. тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр, төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин шагнал, урамшуулал;
- 12.1.7. нэмэлт тайлбар, тодруулга.
- 12.1.8. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ

13.1. Компани нь албан хэргийн хөтлөлт болон бичиг баримтыг хадгалах, холбогдох байгууллагад шилжүүлэх ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулна.

13.1.1. Компани нь дараах бичиг баримтыг хадгална.

13.1.1.1. компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

13.1.1.2. хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага болон компанийн дотоод бичиг баримт;

13.1.1.3. нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт;

13.1.1.4. хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, түүний хороодын хурлын тэмдэглэл, дүгнэлт, шийдвэр, Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр;

13.1.1.5. аудитын хороо, хөндлөнгийн аудиторын дүгнэлт, тайлан;

13.1.1.6. санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

13.1.1.7. анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн бичиг баримт.

13.2. Компани нь бичиг баримтыг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газарт хадгална.

АРВАН ДӨРӨВ. БУСАД

14.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй аливаа асуудал нь Компанийн тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль, "Хөрөнгө оруулалтын тухай" хууль, Үйл ажиллагааны журам болон холбогдох бусад хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан бодлого, шийдвэр, болон энэхүү дүрмийн хүрээнд холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана.

14.2. Компанийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, компанитай гэрээгээр ажиллаж байгаа этгээд компанийн нууцад хамаарах мэдээллийг хууль тогтоомжид тусгайлан заасан буюу төрийн эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд компаниас бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр ашиглаж эсхүл задруулж болохгүй.

14.3. Энэхүү дүрэм нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

14.4. Энэхүү дүрмийг зөрчиж гаргасан аливаа шийдвэр нь хүчин төгөлдөр бус байна.

